



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 дугаар сарын 21 өдөр Дугаар 21.

Хэрлэн сум

XXI ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын хурал Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу цомхотгосон хэлбэрээр 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 12:30 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат даргалж, холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Улсын Онцгой комиссын Шуурхай штабын дарга Б.Ууганбаярын өгсөн "Ариутгал халдваргүйтгэл хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" албан бичгийг танилцуулах Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах,

2. Дорнод аймгийн хилийн Эрээнцав, Ульхан боомтоор 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр ОХУ-аас хил нэвтрэн орж ирсэн Монгол Улсын иргэдийн мэдээллийг Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяад:

1.1. Тусгаарлах байрны зардлыг төлүүлэх асуудлыг хүлээн зөвшөөрсөн тухай маягтыг боловсруулан иргэдээр баталгаа гаргуулж ажиллахыг,

Хоёр. Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:


2.1. УОК-ын Шуурхай штабаас өгсөн чиглэлийн дагуу 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 20:00 цагаас өмнө хилийн Эрээнцав, Ульхан боомтоор ОХУ-аас хил нэвтрэн орж ирсэн Монгол Улсын иргэдийг Чойбалсан хот руу тээвэрлэхэд хяналт тавьж ажиллахыг,


Гурав. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаад:

3.1. Тусгаарлах байрны зардлыг нэг өдөрт том хүн-25,000 төгрөг, 0-12 хүртэлх насны хүүхэд-15,000 төгрөг болгохыг,

Дөрөв. Чулуунхороот, Баян-Уул сумын Засаг дарга нарт

4.1. 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 20:00 цагаас өмнө хилийн Эрэнцав, Ульхан боомтуудаар ОХУ-аас хилээр нэвтэрсэн Монгол улсын иргэдийг Чойбалсан хот руу зөөвөрлөх ажилд автомашины бэлтгэл, бэлэн байдлыг хангахыг тус тус үүрэг болголоо.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ӨНЦГОЙ КОМИССЫН  
ОРЛОГЧ ДАРГА  ӨНЦГОЙ КОМИССЫН  
Ч.ГАНБАТ

АЙМГИЙН ӨНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА